

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 14-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-8
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9-24

- 1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар 2023.04.05-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

9-19
- 2. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/*

20-22
- 3. Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай/*

22-24

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
06 дугаар сарын 14-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, Ё.Баатарбилэг, Т.Доржханд,
Л.Оюун-Эрдэнэ,;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн 2023.04.05-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нар 2023.04.05-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, мөн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга А.Энхмаа, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, Судлаач, доктор Э.Гэрэлт-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Э.Бат-Амгалан, Б.Баттөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл, Ц.Туваан, Б.Энх-Амгалан, Б.Энхбаяр /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 17 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 29.10 дахь хэсэг болгох:

17/29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг:

“29.10.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтын 41.16 дахь хэсгийг хасаж, мөн заалтын 41.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.16 дахь хэсэг болгох:

“41.16.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 26 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26/47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:

“47.12.Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: 4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30.3 дахь хэсэг болгон 1 дүгээр зүйлд нэмэх:

“4/30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсгийн “бөгөөд” гэсний дараа “энэ хуульд заасны дагуу урьдчилан санал авсан битүүмжилсэн саналын хайрцаг,” гэж,” гэснийг, 4 дүгээр зүйлийн “20 дугаар зүйлийн 20.11, 23.1, 24.1, 24.2, 24.3 дахь хэсгийн “14-өөс” гэснийг “16-аас” гэж, 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж,” гэснийг, “23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “гурваас” гэснийг “таваас” гэж,” гэснийг, “41.6 дахь хэсгийн “20-оос” гэснийг “10-аас” гэж,” гэснийг, “42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас” гэж,” гэснийг, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн “харгалзан Сонгуулийн ерөнхий хороо болон Монгол Улсын Ерөнхий аудитор хамтран батална.” гэснийг “үндэслэл болгоно.” гэж,” гэснийг, “61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсгийн “гурваас” гэснийг “таваас” гэж,” гэснийг, 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “, төвийг” гэснийг,” гэснийг, “29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд” гэснийг,” гэснийг, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш” гэснийг,” гэснийг, 6 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2, 12 дугаар зүйлийн 12.4, 14.12 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэг” гэснийг, “30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг,” гэснийг, “50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг,” гэснийг, “, 65 дугаар зүйлийн 65.6 дахь заалтыг” гэснийг, “26.3.5,” гэснийг, 7 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийн дугаарыг 20.15, 20.17 дахь хэсгийн дугаарыг 20.16 гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: 6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтын “ухуулах” гэсний дараа “буюу зурагт” гэж, 41.2 дахь хэсгийн “эвслийн” гэсний дараа “тойрогт” гэж,” гэж, 4 дүгээр зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41.3 дахь хэсгийн “Ухуулах хуудас болон зурагт” гэснийг “Зурагт” гэж, 41.11 дэх хэсгийн “нам, эвсэл, нэр дэвшигчийн зурагт болон ухуулах хуудсыг” гэснийг “зурагт самбарыг” гэж,” гэж, мөн зүйлийн “32.12” гэсний дараа “, 38.12” гэж, 5 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн” гэсний өмнө “10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “улсын төсвөөс санхүүжих” гэснийг,” гэж, мөн зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийн “, ухуулах хуудас” гэснийг,” гэж, 6 дугаар зүйлийн “21 дүгээр зүйлийн” гэсний өмнө “20 дугаар зүйлийн 20.6.7 дахь заалт” гэж тус тус нэмж, 6 дугаар зүйлийн “23.3.4” гэснийг “26.3.4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-д анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь өөр хоорондоо, эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх энэ хуулийн 38.2-т заасан эрх зүйн дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо дэмжиж санал, дүгнэлт гаргасны дагуу санал хураалт явуулав.

Н.Энхболд: 7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5/42 дугаар зүйл.

42 дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглах

42.1.Тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбар /цаашид “нэгдсэн самбар” гэх/-ыг сум, дүүргийн Засаг дарга дараах шаардлагын дагуу бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна:

42.1.1.нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байх;

42.1.2.зурагт хуудас байрлуулах дарааллыг энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтоох;

42.1.3.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, аймгийн төвийн суманд тав хүртэл, хороонд дөрөв хүртэл нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй байрлуулах.

42.2.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.

42.3.Зурагт самбарыг зөвхөн нийтийн эзэмшлийн газар буюу гудамж, талбайд сурталчилгааны хугацаанд түр хугацаагаар, үнэ төлбөргүй байрлуулна. Зурагт самбарт тухайн нам, эвслийн нэрийг дурдсан байна.

42.4.Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.

42.5.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга, байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулахгүй.

42.6.Нэгдсэн самбар болон зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: 8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “34.1.1 дэх заалт” гэсний дараа “41 дүгээр зүйлийн 41.6, 41.7, 41.12 дахь хэсэг” гэж, мөн зүйлийн “тус тус” гэсний өмнө “66 дугаар зүйлийн 66.14 дэх хэсгийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: 9.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дугаар зүйл нэмэх:

“8 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Н.Энхболд: Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 0
Бүгд: 10
100.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Энхболд: 10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсгийн “таваас” гэснийг “гурваас” гэж, мөн зүйлийн 11 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.21 дэх хэсгийн “нягтлах эрхтэй” гэснийг “болно” гэж өөрчилж, 2 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу 66 дугаар зүйлийн 66.5 дахь хэсгийн “саналаа тэмдэглэсэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ

Н.Энхболд: 11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг 2 дугаар зүйлийн 2 дахь заалт болгон шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 0
Бүгд: 10
100.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ

Н.Энхболд: 12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн” гэсний дараах ““20-оос” гэснийг “40-өөс” гэж” гэснийг ““20-оос” гэснийг “30-аас” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, М.Оюунчимэг, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3

Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Дэнсмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн нар байлцав.

Төсвийн төслийн талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 57 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
14 цаг 18 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Хуралдааны ирцийг танилцуулъя. Энэ хаашаа алга болчхов? Ганболд гишүүн ирсэн байна. Нямбаатар гишүүн ирсэн байна. Амарсайхан гишүүн ирсэн. Оюунчимэг гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Н.Энхболд гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Эрдэнэбат гишүүн, Бямбацогт гишүүн, Сарангэрэл гишүүн ирж хуралдааны ирц бүрдсэн учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 6 сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудаа танилцуулъя.

Нэгдүгээрт Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 23 оны төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. Энэ хуулийн төслүүдийг Засгийн газраас 6 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлгээ хийнэ.

Бид санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлэх дэгтэй.

Хоёрдугаарт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүд байгаа. Их Хурлын

Гишүүн Энхболд нарын 4 гишүүн 4 сарын 5-ны өдөр, Их Хурлын гишүүн Цогтгэрэл нарын 2 гишүүн 4 сарын 5-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн төслүүд өнөөдөр эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

Бусад асуудал төлөвлөгдсөн байгаа. Бусад асуудлын хүрээнд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн хуулиар заасан горимын саналд хэлэлцэж байгаа холбогдол асуудалтай холбогдуулаад дараалал, журмын талаар гарсан саналыг хэлнэ гэсэн заалт бий. Энэ талаар асуулт, санал гарсангүй. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. За байз энэ Тусгай хяналтын дэд хорооны хуралдаан дуусаагүй байдаг яах вэ? Шууд Сонгуулийнхаа хуульд орчих уу? Тэгье тэгвэл. Тус хяналтын дэд хорооны хурлын санал, дүгнэлт ирэнгүүт Төсвийн хуулиа ярья.

Ингээд Сонгуулийн тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Эцсийн хувилбарын төсөл эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Танилцуулга хаа байна? Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн танилцуулна.

Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Т.Доржханд, Л. Мөнхбаатар, Тогтохсүрэн нараас 2023 оны 4 сарын 5-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн

Цогтгэрэл, Ганбат нараас 2023 оны 4 сарын 5-ны өдөр тус тус Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгтгэсэн төслийн анхны хэлэлцүүлгийг 2023 оны 6 сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Ажлын хэсэг 2023 оны 6 сарын 13-ны өдөр хуралдаж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэлээ. Анхны хэлэлцүүлгээр хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 6 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг, мөн анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-т заасны дагуу гаргасан эрх зүйн дүгнэлтийн хүрээнд 3 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Байнгын хорооны гишүүдийн 3-ны 2-ын саналаар дахин санал хураалгах 3 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тус тус бэлтгэсэн болно.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд нь агуулгын хувьд дараах хүрээг хамарч байгаа болно. Үүнд:

Тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбартай байх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан 42 дугаар зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулж, 41 дүгээр зүйлийн зарим хэсгийг хасах, өөрчлөх, бэхэн тэмдэглэгээ хийхтэй холбогдсон зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан 66 дугаар зүйлийн 66.14 дэх хэсгийг хасах, нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, иударга ёсны зарчмыг баримталж нийгмийн

бүлгийн төлөөллийг харгалзан үзэх гэж томъёолсон. Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь 3 хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байх, цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байх.

Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчдээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглох зэрэг хүрээг хамарч байгаа болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээ боловсруулан оруулж байгаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар чуулганы хуралдааны дэгийн тухай 38.2-т заасны дагуу эрх зүйн дүгнэлт гаргуулахаар бид хандсан. Энэ талаар гаргасан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Нямбаатар сайд танилцуулна.

Х.Нямбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн болон Монгол Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Ганбат нараас 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар санал хурааж дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зохицуулалттай

зөрчилдсөн эсэх, хэрхэн нийцүүлэх, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор нэгтгэсэн төслийн дагаж мөрдөх хугацааг нийцүүлэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны хууль зүйн дүгнэлт гаргуулах тухай шийдвэрийн дагуу Монгол Улсын Их Хурлын Тамгын газар 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдөр хууль зүйн дүгнэлт гарган Хууль зүйн байнгын хороонд ирүүлснийг Байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль зүйн дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Үнэнбат танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганбат сонгогч саналаа өгснийг илэрхийлэх, бэхэн тэмдэглэг болон нэгдсэн самбарын талаар асуулт асууж хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 53.8 хувийн хувь нь Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль, зүйн дүгнэлтийг дэмжиж, Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн хууль зүйн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Н.Энхболд: Нямбаатар сайдад баярлалаа. Би хууль зүйн дүгнэлтийг нь уншаад танилцуулъя.

Хууль зүйн дүгнэлт, дугаар 2023, 01 Хууль зүйн дүгнэлт гарах үндэслэл

Их Хурлын гишүүн Энхболд нарын 4 гишүүн болон Их Хурлын гишүүн Цогтгэрэл, Ганбат нараас 23 оны 4 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны хууль зүйн дүгнэлт гаргуулах тухай 23 оны 6 сарын 8-ны өдрийн шийдвэр Улсын Их Хурлын Тамгын газарт 23 оны 6 сарын 8-ны өдөр ирүүлсэн алба тоот албан бичгийг тус тус үндэслэн энэ дүгнэлтийг гаргасан.

Ингээж дүгнэлт гаргахдаа хууль зүйн дүгнэлт гаргах журмыг баримталсан байна. Хууль зүйн дүгнэлтийн хүрээ, хязгаар нь ийм дүгнэлт гаргахад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаар санал хурааж дэмжигдсэн зарим зарчмын зөрүүтэй саналын томъёолол Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалттай зөрчилдсөн эсэх, хэрхэн нийцүүлэх, түүнчлэн Үндсэн хуульд оролцсон өөрчлөлттэй холбоотойгоор нэгтгэсэн төслийн дагаж мөрдөх хугацааг нийцүүлэх талаар Үндсэн хууль бусад хуулиудтай нийцэж байгаа эсэх, хэрэгжих боломжийн талаар эрх зүйн дүн шинжилгээ хийлгэх тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос өгсөн чиглэлийг үндэс болгосон.

Нэгдүгээрт, анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь бусад хуультай нийцэж байгаа эсэх талаар

Төрийн байгуулалтын байнгын хороо 06 сарын 07-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийг хэлэлцэхэд нэгтгэсэн төсөлд хөндөгдсөн 2 дугаар зүйлийн 16 дахь заалт буюу 66.5, 4 дүгээр зүйлийн зүйл буюу 38.12, 42.1-ийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг

хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн байна.

Санал хурааж дэмжигдсэн эдгээр саналын томъёолол Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдсөн эсэх талаар дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглахтай холбоотой зохицуулалтын талаар өргөн мэдүүлсэн нэгтгэсэн төсөлд 40.2.1 сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар, дэлгэц ашиглаж болох ба зурагт самбар, дэлгэц нь 1 хэсэгт 10-аас аймгийн төв болон дүүргийн хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас илүүгүй байна гэж тусгасныг Байнгын хорооны анхны хэлэлцүүлгээр сонгуулийн зардлыг бууруулах зорилгоор тойрог тус бүрд нэр дэвшигчийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбартай байх зохицуулалтыг доор дурдсанаар өөрчилсөн байна.

Тойрог тус бүрд нэр дэвшигчийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбартай байна. Сум дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан журмын дагуу нэгдсэн самбарыг бэлтгэж байрлуулах ажлыг зохион байгуулна. Нэгдсэн самбар дараах шаардлагыг хангасан байна.

42.1.1. Энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн зурагт хуудсыг байрлуулах дарааллыг тогтооно.

42.1.2. Сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй ашиглуулна

42.1.3. Нэгдсэн самбарт байрлуулах нэр дэвшигчийн зурагт хуудас нь 1 хэвлэлийн хуудасны 4-ний 1 хэмжээтэй байна.

42.1.4. Сонгогчийн тоонд үндэслэн сумд 2 хүртэл, хороонд 3 хүртэл нэгдсэн самбар байрлуулна.

Зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбарыг Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан журмын дагуу сум дүүргийн Засаг дарга бэлтгэж байрлуулах, нэгдсэн самбар нь үнэ төлбөргүй байх зохицуулалтыг дэмжсэнтэй холбогдуулан хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2, 42.3, 42.4, 42.6, 42.7, 42.8 дахь хэсгүүдэд дурдсан зурагт самбар, дэлгэц гэсэн нэр томъёог нийцүүлэх, зурагт самбарыг байрлуулах, нам, эвслээс нэр дэвшигчдийг байрлуулах дараалал зэргийг заасан бусад зохицуулалтыг нийцүүлж өөрчлөх шаардлагатай тул 42 дугаар зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулах саналтай байна.

Түүнчлэн тойргоос нэр дэвшигч судалгааны нэгдсэн самбартай байх зохицуулалт дэмжигдсэн тул хуулийн 41.3, 41.7, 41.11-т тус тус заасан ухуулах хуудас гэсэн нэр томъёог хасах, тухайн хэсгийг өөрчлөн найруулах эсэхийг шийдвэрлэх хэрэгтэй байна.

2. Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх, бэхийн тэмдэглэгээ хийх зохицуулалт дэмжигдсэн бөгөөд 66.5 сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж, саналын хайрцагт хийсний дараа тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол нь хуулийн 66.14 сонгогч саналаа өгснийг илэрхийлэх аливаа тэмдэг, тэмдэглэгээ хийхийг хориглоно гэсэн зохицуулалттай зөрчилдөж байна.

Иймд төсөлд хуулийн 66.14 дэх заалтыг хасах зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.

3. Нэгтгэсэн төсөлд сонгуулийн сурталчилгааны хугацааг багасгаж 18 хоног болгон өөрчилсөнтэй холбоотойгоор 38.12 дахь хэсэгт төрийн аудитын дээд байгууллага нь энэ хуулийн

26.3.6, 26.4.6-д заасан тайлан, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнөөс эхлэн энэ хуульд заасны дагуу нам, эвсэл болон бие даан нэр дэвших сонгуулийн зардлын тайлангаа хүргүүлэх өдрийг дуустал өөрийн байгууллагын цахим хуудаст нээлттэйгээр байршуулна гэж заасантай зөрчилдөхөөр байна.

Иймд хуулийн 38.12 дахь хэсэгт заасан 22.1-ийг нийцүүлж 18 хоног болгох шаардлагатай байна.

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор нэгтгэсэн төслийн дагаж мөрдөх хугацааг нийцүүлэх талаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нараас 23 оны 4 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Их Хурлын сонгуулийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дагаж мөрдөх хугацааны талаарх зохицуулалтыг тусгаагүй байна.

23 оны 5 сарын 31-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 24 оны 1 сарын 1-ний өдрөөс нь дагаж мөрдөхтэй холбогдуулан хуулийн төсөлд дагаж мөрдөх хугацааг нийцүүлж тодорхой болгох шаардлагатай байна гэсэн дүгнэлт ирүүлсэн.

Танилцуулгатай холбогдож асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал хураалтуудаа явуулж эхэлнэ. Эхлээд ажлын хэсгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураана. Саналууд маань хаа байна? Тийм энэ байна тээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Дэлгэрнаран, Цахим

хөгжил, харилцаа, холбооны дэд сайд Эрхэмбаатар, Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга Баяндүүрэн, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Болд, Үндэсний Аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, Тэргүүлэх аудитор Бундхорол. Бундхорол ирсэн үү? Харилцаа, холбоог зохицуулах хорооны Ажлын албаны дарга Лувсан-Очир, Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Энхмаа, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн Наранцэцэг, судлаач доктор Гэрэлт-Од ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг орж байна.

Одоо ажлын хэсгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураана. Гишүүдийг анхааралтай байхыг хүсье.

Нэгдүгээрт хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн саналуудаар хураалгана. Санал хураана.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 17 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 29.10 дахь хэсэг болгох:

17/29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсэг:

“29.10.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмыг баримталж, нийгмийн бүлгийн төлөөллийг харгалзана.” гэсэн үгээр солиод ажлын хэсгээс гаргасан санал байна. Санал хураалт.

90 хувийн саналаар санал дэмжигдэж байна. Ганболд гишүүн ирсэн байгаа юу?

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дэх заалтын 41.16 дахь хэсгийг хасаж, мөн

заалтын 41.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.16 дахь хэсэг болгох:

“41.16.Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудаснаас хэтрэхгүй байна.” Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт.

90 хувиар санал дэмжигдэж байна.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 26 дахь заалт буюу 47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26/47 дугаар зүйлийн 47.12 дахь хэсэг:

“47.12.Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах зардал энэ хуулийн 50.1-д заасны дагуу тогтоосон зардлын дээд хэмжээний 15 хувиас хэтрэхгүй байна.” Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт.

90 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 30.3 дахь хэсэг болгон 1 дүгээр зүйлд нэмэх:

“4/30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ намын гишүүн, дэмжигчээсээ мөнгөн болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ, барьцаа, дэнчин авахыг хориглоно.” Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт.

Сүүлд 100 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн “65 дугаар зүйлийн 65.4 дэх хэсгийн “бөгөөд”

гэсний дараа “энэ хуульд заасны дагуу урьдчилан санал авсан битүүмжилсэн саналын хайрцаг,” гэж,” гэснийг, 4 дүгээр зүйлийн “20 дугаар зүйлийн 20.11, 23.1, 24.1, 24.2, 24.3 дахь хэсгийн “14-өөс” гэснийг “16-аас” гэж, 20 дугаар зүйлийн 20.11 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж,” гэснийг, “23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “14-өөс доошгүй” гэснийг “5-аас доошгүй” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “гурваас” гэснийг “таваас” гэж,” гэснийг, “41.6 дахь хэсгийн “20-оос” гэснийг “10-аас” гэж,” гэснийг, “42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “аймгийн төв болон дүүргийн нэг хэсэгт 5, бусад хэсэгт 3-аас” гэж,” гэснийг, “50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийн “харгалзан Сонгуулийн ерөнхий хороо болон Монгол Улсын Ерөнхий аудитор хамтран батална.” гэснийг “үндэслэл болгоно.” гэж,” гэснийг, “61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсгийн “гурваас” гэснийг “таваас” гэж,” гэснийг, 5 дугаар зүйлийн “13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “, төвийг” гэснийг,” гэснийг, “29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийн “ээлжит сонгуулийн тухайд ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд” гэснийг,” гэснийг, “54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “нам, эвсэлд, эсхүл нэр дэвшигчид зардлын данс нээсэн өдрөөс хойш” гэснийг,” гэснийг, 6 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2, 12 дугаар зүйлийн 12.4, 14.12 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.15 дахь хэсэг” гэснийг, “30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг,” гэснийг, “50 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг,” гэснийг, “, 65 дугаар зүйлийн 65.6 дахь заалтыг” гэснийг, “26.3.5,” гэснийг, 7 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн 20.16 дахь хэсгийн дугаарыг 20.15, 20.17 дахь хэсгийн дугаарыг 20.16 гэж,” гэснийг тус тус хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

100 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтын “ухуулах” гэсний дараа “буюу зурагт” гэж, 41.2 дахь хэсгийн “эвслийн” гэсний дараа “тойрогт” гэж,” гэж, 4 дүгээр зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41.3 дахь хэсгийн “Ухуулах хуудас болон зурагт” гэснийг “Зурагт” гэж, 41.11 дэх хэсгийн “нам, эвсэл, нэр дэвшигчийн зурагт болон ухуулах хуудсыг” гэснийг “зурагт самбарыг” гэж,” мөн зүйлийн “32.12” гэсний дараа “, 38.12” гэж, 5 дугаар зүйлийн “20 дугаар зүйлийн” гэсний өмнө “10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “улсын төсвөөс санхүүжих” гэснийг,” гэж, мөн зүйлийн “46 дугаар зүйлийн” гэсний өмнө “41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийн “, ухуулах хуудас” гэснийг,” гэж, 6 дугаар зүйлийн “21 дүгээр зүйлийн” гэсний өмнө “20 дугаар зүйлийн 20.6.7 дахь заалт” гэж тус тус нэмж, 6 дугаар зүйлийн “23.3.4” гэснийг “26.3.4” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

Хоёрдугаарт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2-т заасны дагуу гарсан эрх зүйн дүгнэлттэй холбогдуулан боловсруулсан саналууд байна.

7 дугаар санал. Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5/42 дугаар зүйл.

42 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар ашиглах

42.1.Тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан нэгдсэн самбар /цаашид “нэгдсэн самбар” гэх/-ыг сум, дүүргийн Засаг дарга дараах шаардлагын дагуу бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулна:

42.1.1.нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг хэмжээтэй байх;

42.1.2.зурагт хуудас байрлуулах дарааллыг энэ хуулийн 60 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтоох;

42.1.3.сонгогчийн тоонд үндэслэн суманд хоёр хүртэл, аймгийн төвийн суманд тав хүртэл, хороонд дөрөв хүртэл нэгдсэн самбарыг үнэ төлбөргүй байрлуулах.

42.2.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэл байрлуулж болно.

42.3.Зурагт самбарыг зөвхөн нийтийн эзэмшлийн газар буюу гудамж, талбайд сурталчилгааны хугацаанд түр хугацаагаар, үнэ төлбөргүй байрлуулна. Зурагт самбарт тухайн нам, эвслийн нэрийг дурдсан байна.

42.4.Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.

42.5.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга, байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулахгүй.

42.6.Нэгдсэн самбар болон зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.” гэж ажлын хэсгээс гаргасан саналыг дэмжье. Санал хураалт.

100 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 6 дугаар зүйлийн “34.1.1 дэх заалт” гэсний дараа “41 дүгээр зүйлийн 41.6, 41.7, 41.12 дахь хэсэг” гэж, мөн зүйлийн “тус тус” гэсний өмнө “66 дугаар зүйлийн 66.14 дэх хэсгийг” гэж

нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье.
Санал хураалт.

100 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төсөлд доор дурдсан агуулгатай
8 дугаар зүйл нэмэх:

“8 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Ажлын хэсгийн саналыг дэмжье.

80 хувийн саналаар дэмжигдлээ.

Амарсайхан, Оюунчимэг гишүүд хоцорсон байна шүү. Анхааралтай байгаарай.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т заасны дагуу санал хураалгах ёстой.

Эхлээд дэгээрээ хураалгана. Дараа гарах саналуудыг 3-ны 2-оос. Дэгээ уншаад танилцуулчихъя.

42.2.3.Нэгдсэн хуралдааны анхдугаар хэлэлцүүлгээр санал хураамж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн байх учиртай 2, 3 санал байгаа.

Эхлээд дэгээрээ хураалгачихъя. 3-ны 2-оор дэмжинэ гэдгээ дэмжиж санал хураалгая. Санал хураалт. Дэгийн санал шүү.

Хураалгадаг юм байна лээ. Тийм угаасаа хуультай. Тэгэхдээ заавал хураалгах ёстой юм байна лээ. Тэгж ирсэн байдаг юм.

100 хувь.

10 дугаар санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсгийн “таваас” гэснийг “гурваас” гэж, мөн зүйлийн 11

дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.21 дэх хэсгийн “нягтлах эрхтэй” гэснийг “болно” гэж өөрчилж, 2 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу 66 дугаар зүйлийн 66.5 дахь хэсгийн “саналаа тэмдэглэсэн” гэснийг хасах. Ажлын хэсгийн санал. Санал хураалт.

90 хувийн саналаар дэмжигдлээ.

Ер нь санал болгоноор, зарчмын зөрүүтэй санал болгон дээр дэгээрээ санал хураалгах ёстой юм байна.

Одоо 11 дүгээр санал буюу Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг 2 дугаар зүйлийн 2 дахь заалт болгон шилжүүлэх гэдэг асуудлыг 3-ны 2-оор шийдье гэсэн горимын саналаар санал хураалгана. Санал хураалт.

Горимын саналыг 100 хувиар дэмжсэн байна. Одоо саналаа хураана.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг 2 дугаар зүйлийн 2 дахь заалт болгон шилжүүлэх. Ажлын хэсгийн санал. Санал хураалт.

Горимын санал 100 хувиар дэмжигдлээ. Саналаа хураачихсан бил үү. Одоо дахиад горимын санал уу?

Төслийн 4 дүгээр зүйлийн “30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн” гэснийг дараах ““20-оос” гэснийг “40-өөс” гэж” гэснийг ““20-оос” гэснийг “30-аас” гэж” өөрчлөх. Энэ саналыг 3-ны 2-оор хэлэлцэх нь зүйтэй. Хураалгая гэсэн горимын саналаар санал хураалгая. Санал.

Горим дэмжигдсэн учраас одоо саналаа хураана.

Төслийн 4 дүгээр зүйлийн “30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн” гэснийг дараах ““20-оос” гэснийг “40-өөс” гэж” гэснийг ““20-оос” гэснийг “30-аас” гэж” өөрчлөх. Ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулна.

Санал дээр үг хэлэх дэг байгаа билүү, байгаа юу? Сарангэрэл гишүүн, Оюунчимэг гишүүн, Булгантуяа гишүүн нэрсээ. Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Хүйсийн тэгш байдалтай холбоотой сонгуулийн хуулийн заалт дээр бид бас өнөөдөр ухралт хийх гээд байж байна л даа. Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр хэлэлцүүлгээр тойрогт нэр дэвших эмэгтэйчүүдийн квотыг 40 хувь байх нь зүйтэй гэж Улсын Их Хурлын гишүүд өөрсдийнхөө итгэл үнэмшилээр саналаа өгсөн. Санал бол 50:50 буюу 21:21 та нар бас энэ тоог ч гэсэн ингээд бодоод үзэхгүй юу. Өчигдөрхөн бол Монгол Улс дэлхийн сонорт, мэлмийд хүрсэн томоохон үйл явдал форум зохион байгууллаа. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Бан Ги Мун дарга, мөн олон улсын төлөөлөгчтэй оролцсон. Энэ нь өөрөө тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын 17 заалт буюу 5 дахид нь байгаа хүйсийн тэгш байдлыг нийгмийн бүхий л харилцаанд ижил, тэгш байлгах тухай асуудлаар бид ийм том үйл ажиллагаа явуулсан.

Тэгээд яг энэ үйл ажиллагааны үеэр тэрний өмнөхөн нь Их Хурал дээрээ баталсан энэ квотын хүйсийн тэгш байдлынхаа асуудлыг 40 хувийг 30 болгож бууруулъя гээд бид нар өнөөдөр Байнгын хорооны хурал дээрээ хэлэлцээд санал хураах гээд ухралт хийх гээд байж байгаатай санал нийлэхгүй байна.

Нийт 126 гишүүн дээр та бүхэн тооцоо хийгээд л байгаа. 40 хувь гэдэг маань тойрог болон жагсаалтын нийлбэр дүн юм байгаа юм. Ер нь энэ нийлбэр дүнгээс харахад бол одоогийн 17 гишүүн 7-гоор нэмэгдээд, 126-гийн 25 нь эмэгтэй, 101 нь эрэгтэй л байх юм байна лээ л дээ. Энэ дээр манай эрчүүд ингэтлээ их бачимдаж, чичирч байгааг би ойлгохгүй байгаа юм.

Дахин хэлэхэд Улсын Их Хуралд сууж байгаа 80:20-ийн харьцаатай байгаа энэ эмэгтэй гишүүдийн асуудал биш шүү дээ. Зарим нь ч дэвших байх, зарим нь дэвшихгүй ч байх янз янз л байна. Тэгээд энэ 17 эмэгтэй гишүүн өөрсдөө гарах гээд ингээд байна гэдэг ийм буруу ухуулга сурталчилгаа явуулж байгаа нь үнэхээр харамсалтай. Энэ бол Монгол Улсын хүн амын 51.3 хувь, 50-аас илүү хувийг эзэлж байгаа эмэгтэйчүүдийн эрхийн тухай асуудал юм.

Энэ дээр өнөөдөр манай Байнгын хорооны гишүүд тэр дундаа нэгдсэн чуулганаар шийдчихсэн асуудлыг ухралт хийгээд 40-ийг 30 болгоё гээд суух юм бол энэ дэлхий нийтийн өмнө бид шившигтэй байдалд хүрнэ. Нөгөө жендерийн тэгш байдал, дэлхий нийтийн чиг хандлага. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Элбэгдорж өчигдөр энэ форумын үеэр хэвлэлийнхэнд ярилцлага өгсөн байна лээ. Үнэхээр хүн юм бодвол бодохоор, ухаарвал ухаарахаар тийм үндэслэлүүдийг хэлсэн байна лээ. Жендерийн тэгш байдал гэдэг асуудлыг ерөөсөө Монгол Улс эзэн Чингисийн үеэс гаргаж ирсэн юм. Та нар үүх түүхээ эргэж санаарай. Эмэгтэйчүүд орж ирснээрээ улс төр болохоо байчих юм байхгүй ээ. Тэгш байдал гэдэг бол бүх салбарт тогтвортой, тэнцвэртэй хөгжлийн суурь байдаг юм гэдгийг маш ойлгомжтой, энгийн байдлаар тайлбарлаж хэлсэн.

Тэгээд нэгэнт шийдсэн асуудлыг тэгээд дэлхий нийтийн зарчмаас ухаръя гээд ингээд ороод ирж байгаа, ингэж зүрхэлнэ гэдэг ерөөсөө байж болохгүй асуудал. Төрийн байгуулалтын байнгын хороонд 3 эмэгтэй гишүүн байдаг, бусад нь эрэгтэй. Тэгээд би эрэгтэй гишүүдийгээ энэ асуудалд илүү ухамсартай байна байх гэж бодож байна. Та бүхэн сонгуульд бүгд нэр дэвшинэ байх.

Хэрвээ энэ дээр ийм ухралт хийх шийдэл гаргах юм бол тойрогт байгаа

эмэгтэйчүүд та бүхнийг дэмжихгүй гэдэгт би бүрэн дүүрэн итгэлтэй байна. Бид энэ чиглэлээр ч гэсэн ажиллах болно.

Ер нь бол энэ асуудлыг өөрөө хөндөж байгаа нь хүний эрх, тэгш байдал, ардчилал, социал демократ үзэл баримтлалынхаа хэлж ярьж байсан юмныхаа эсрэг явж байгаа гэдгийг.../минут дуусав./

Н.Энхболд: Баярлалаа. Оюунчимэг гишүүн үг хэлье.

М.Оюунчимэг: Бид нар энд жендерийн асуудал гэхээр эмэгтэйчүүд, эмэгтэй гишүүд асуудал хөндөөд байгаа юм шиг л бодоод байгаа. Энэ бол тийм биш л дээ. Ер нь энэ олон улсын өчигдрийн манай улсын энэ сая бас Сарангэрэл гишүүн хэлж байна. Нэр хүндийг өргөсөн том арга хэмжээ ч болж байна. Жендерт суурилсан тогтвортой хөгжлийн асуудал өөрөө өнөөдөр дэлхийн улс орнуудын хувьд хамгийн чухал болж байгаа.

Өнөөдөр аз жаргалын индекс буюу Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хамгийн амжилттай хэрэгжүүлж байгаа Скандинавын орнууд зэргийг аваад үзэхэд яг жендерийн адил, тэгш эрх байдал нь шийдвэр гаргах түвшин дээр бүрэн хангагдаж чадсан нь өнөөдөр тэр улсад бүх асуудлууд бараг шийдэгдэж байна шүү дээ. 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнээс өгсүүлээд.

Тэгэхээр би манай Монгол Улсын хувьд энэ жендерийн тэгш байдал маань алдагдаад байгаагийн сөрөг үр дагавар нь өнгөрсөн 30 жилд энэ агаар, хөрсний бохирдол, энэ түгжрэл, энэ газрын наймаа, тэгээд сургууль, цэцэрлэг хэдэн ээлжээр хичээллэж ямар байлаа бид бүгдээрээ мэднэ.

2012 онд 11 эмэгтэй, 16 онд 13 эмэгтэй, 20 оны сонгуулиар 13 эмэгтэй Улсын Их Хуралд орж ирсний үр дүнд бас хүүхэд хамгаалал дээр жишээлбэл

жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг бид анх удаа хийж чадаж байсан. Энэний үр дүнд жишээлбэл өнөөдөр 3 ээлж хичээллэдэг явдал халсан. Ясли, цэцэрлэгт морь, сугалаагаар очерлож байгаад үүрийн 3, 4 цагт залуу аав, ээж нар яаж очерлодог байлаа. Энийг бид бас халж чадсан төсөв мөнгө хэлэлцэх үед.

Энэ нь өөрөө юу юм гэхээр жендерийн баланс, тэгш байдлыг хангах нь асуудал нь өөрөө бас ямар их ач холбогдолтой гэдгийг нэг зүгээр жишээ л дээ.

Одоо хүүхэд хамгааллын төсөв гэхэд тэрбум төгрөг хүрдэггүй байсныг бид өнөөдөр олон улсын жишигт арай дөхүүлж 11-13 тэрбум төгрөгт авчирсан. Энэ нь өөрөө өнөөдөр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын чиглэлийн үйл ажиллагаануудыг явуулах, тэр хүүхдийн байцаагчийг ажиллуулах зэрэгт их үр дүн өгсөн л дөө.

Тэгээд энд яригдаад байгаа энэ 30, 40 хувь нь зүгээр өнөөдөр Улсын Их Хуралд хэдэн хүн нэр дэвшигдэх гээд байгаадаа биш зүгээр бид жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт, санхүүжилт, үүний үр дүнд улс орны хөгжил тогтвортой хөгжил нь яваасай, Монгол Улсын хүний хөгжлийн асуудал өндөрт тавигдаасай, энэ нийгмийн асуудлууд, ялангуяа утаа, энэ агаар, хөрс, түгжрэл, эрүүл мэндийн асуудал, боловсролын асуудал, хөдөлмөрийн зах зээлийн энэ асуудлууд дээр энэ тэнцвэртэй байдал алдагдсаны сөрөг үр дагавар байгааг энийг л засъя гэдэг үүднээс бид энд хандаж байгаа шүү гэдгийг би хэлье гэж бодож байна. Баярлалаа.

Н.Энхболд: Оюунчимэг гишүүнд баярлалаа. Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Одоо нийгэм, эмэгтэйчүүд ордны гадаа бүр жагсаад л, эрэгтэй, эмэгтэй гэлтгүй бүх хүмүүст бичиг өгөөд л, хүүхдүүдээ хүртэл дагуулаад ирчихсэн, тэргэнцэртэй

хүмүүс, эмэгтэйчүүд хүртэл ирээд л бид нарын нөгөө микрофон дээр үг хэлэх эрхийг тэгээд яагаад ингэж аймаар зууралдаад байгаа юм бэ. Парламент өөрсдийнхөө эрхийг энэ чинь тоог 40 хувиар нэмлээ шүү дээ. Тэгээд түүн дээр 20 хувиар л эмэгтэйчүүдийн оролцоог өмнөхөөсөө нэмчхээч л гэж л хүсээд байхад ямар ч хяслантай юм бэ дээ гээд л. Бид нараас их юм уг нь бол их гуйгаагүй л байх л даа. Сайд, дарга ч гэдэг юм уу, албан тушаал гэхээсээ илүүтэйгээр хүүхдийн мөнгө, дээрээс нь нэмээд үг хэлэх эрх гээд л иймэрхүү юмны төлөө л тэмцээд байх юм бид нар гэдэг ийм хүсэлтийг тавиад байгаа юм.

Тэгээд энэ чинь 40 хувь гээд парламент дээр очоод сая батлагдчихсан. Энийг одоо ингээд ахиад 30 хувь гээд тэгэхээр дөнгөж саяхан ийм том хурал хийгээд л тэр мэлмийд хүрсэн томоохон үйл явдал форум зохион байгууллаа. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Бан Ги Мун хүртэл ирлээ. Солонгос Улсын Үндэсний Ассамблейн дэд дарга эмэгтэй ирлээ. Бид нар Тогтвортой хөгжлийн зорилгын бусад үзүүлэлтүүдээрээ бас тааруухан л байгаа. Ядаж нэг үзүүлэлтээрээ ч гэсэн ахиц, дэвшил гаргачих юм сан гээд л энэ эмэгтэйчүүд өөрөө өөрсдийнхөө эрх ашгийн төлөө биш бас ийм асуудлаар яриад байгаа юм. Тэгээд эрэгтэй гишүүд маань бас энүүнийг зөв, зүйтэй та бүхэн маань бас ойлгож үзээрэй.

Тэгэхдээ олон улсын судалгаагаар ийм байдаг гэнэ. 10 хувь нэр дэвшилт нэмэгдлээ гэхэд парламентын төлөөлөл 3 хувиар л нэмэгддэг. 10 хувиар нэмэгдлээ гэхэд.

Тэгэхээр 20 хувиар нэмэгдэнэ гэдэг бол одоо 17 хувь дээр бид нар 6 хувь л нэмэгдэх юм шиг байгаа юм. Тэгэхээр та бүхэн нийт төлөөллөө бид нар, ард түмнээ төлөөлөх төлөөллөө 176-гаа бид нар 126 болгоод 40 хувиар нэмчихлээ. Түүн дээр эмэгтэйчүүдийнхээ

төлөөллийг 6 хувиар нэмээд өгөөч л гэж байгаа юм.

Тэрнээс энэ чинь нэр дэвшсэн эмэгтэй болгон гарахгүй тойргоос. Ойлгомжстой. Тэгээд лист дээр байсан эмэгтэйчүүдээс нэг хэсэг нь гарах байх. Тэгээд л тойрог дээр бол мэдээж энэ чинь амаргүй сонголт болно. Ойлгомжстой. Тэгээд түүн дээр гарсангүй гээд эмэгтэйчүүд гомдоллоод байх юм бол байхгүй. Ямар ч байсан эрх тэгш сонгогдох эрхийг маань л олгоод өгөөч л гэж л, үзэх л эрхийг маань олгогдоод өгөөч л гэж байгаа юм.

Тэгээд 40 хувийнхаа нэмэгдэл дотроо 6 хувийн эмэгтэйчүүдийнхээ нэмэгдлийг та бүхэн маань бодчихооч л гэж л хэлж байгаа юм.

Н.Энхболд: Саналтай холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураана.

Ажлын хэсгээс ирүүлсэн Төслийн 4 дүгээр зүйлийн “30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн” гэсний дараах ““20-оос” гэснийг “40-өөс” гэж” гэснийг ““20-оос” гэснийг “30-аас” гэж” гэж өөрчлөх саналыг дэмжих санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 70 хувиар дэмжигдлээ.

Ингээд зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё.

15.00 цаг

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 23 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 23 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. Хоёр дахь хэлэлцүүлгээ хийнэ.

Ажлын хэсгийн гишүүд баярлалаа.
Дараагийн ажлын хэсгийг оруулъя.

Жавхлан сайд, Сангийн сайд Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Энх-Амгалан, Ерөнхий аудитор Занданбат, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Дэлгэрнаран, Төрийн албаны зөвлөлийн дарга Баатарзориг ирэхгүй Баяндүүрэн орчхож байгаа юм уу? Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ганбат, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ариунболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Зулпхар, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Баяндүүрэн, Төрийн албаны зөвлөлийн Сургалт, судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Амармэнд, Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чимэдгаваа, Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батжаргал, мөн яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тунгалагтамир,

Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Төгөлдөр, Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Дэнсмаа, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Дашням, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Уранцэцэг, Зарлагын хэлтсийн мэргэжилтэн Энхманлай гэсэн ажлын хэсэг оролцож байна.

Булгантуяа сайд танилцуулгаа хийчих үү?

Төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Булгантуяа хийнэ.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7.9 хувиар өсөж, гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3.8 тэрбум ам.долларт хүрч сайжраад байна.

Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого, амьжиргааг дэмжих зайлиггүй шаардлага бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас иргэдийнхээ орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч

хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

Тухайлбал, Нэгт хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд олгохын зэрэгцээ хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох, тэтгэврийн зөрөөний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, төрийн албаны цалингийн тогтолцоог шинэчилж, суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын сүлжээг өргөтгөх зэргээр нийслэлийн түгжрэлийг бууруулах арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.

Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.7 их наяд төгрөгөөр, нэгдсэн төсвийн нийт зарлага 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1.6 их наяд төгрөг буюу анх батлагдсан дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувиас хэтрүүлэхгүй байх.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Н.Энхболд: Баярлалаа. Төсвийн тодотголын төслийн талаарх аудитын дүгнэлтийг Наранчимэг дарга танилцуулчих уу? Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түрүүлэн гүйцэтгэгч Наранчимэг 4 номерын микрофон өгөөрэй.

Ц.Наранчимэг: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2023 онд өргөн мэд.../үг тасрав.

Н.Энхболд: Санал гарвал хураана.

Ц.Наранчимэг: Өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд долоон зуун наян.../үг тасрав.

Н.Энхболд: Эрдэнэбат даргаа дараа нь бас санал хураалт байгаа шүү.

Ц.Наранчимэг: ...төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371.4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589.5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.6 хувь байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотгол тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Улсын Их Хурлын даргын төсөв 2023 онд батлагдсан төсвөөс 1.2 тэрбум, Ерөнхий сайдын төсөв 5.4 тэрбум, Шадар сайдын төсөв 21.4 тэрбум, Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсөв 16.2 тэрбум, Төрийн албаны зөвлөлийн даргын төсөв 0.3 тэрбум, Үндэсний аюулгүй байдлын

зөвлөлийн Нарийн бичгийн даргын төсөв 5 тэрбум, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсөв 3.7 тэрбум төгрөгөөр тус тус өөрчлөлт орсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлын төсөв 53.2 тэрбум төгрөгөөр өсөхөд Сонгуулийн хорооны даргын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын төсөвт сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн зардалд 16 тэрбум, урсгал зардлын цалингийн төсөвт, төрийн албан хаагчдын цалин хөлсний системийг шинэчлэн цалинг нэмэгдүүлэн тооцсон, ажил олгогчдоо төлөхөд шаардлагатай нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд болон бусад зардалд 37.2 тэрбум төгрөгийг нэмж төсөвлөсөн нь нөлөөлсөн байна.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна гэж дүгнэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Наранчимэг даргад баярлалаа. Манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаардаг Төсвийн ерөнхийлөн захирагчдын талаарх төсвийн талаар танилцуулгуудыг нь тараасан байгаа гишүүдэд.

Саяын танилцуулгуудтай холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Үг хэлэх, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Ингээд Байнгын хорооноос санал, дүгнэлт гарна. Санал хураахгүй тийм ээ. Санал хураахгүй. Санал, дүгнэлтийг харин хэн танилцуулчихъя даа. Төсөвт үү. Төсвийн байнгын хорооноос

манайхаас чинь Тогтохсүрэн дарга байдаг уу. Хоёр юм танилцуулах болчих юм байна даа. Заавал тэр хорооноос нь байх ёстой юу. Тогтохсүрэн манай санал, дүгнэлтийг танилцуулна.

Монгол Улсын 23 оны төсвийн модотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

15.08 цаг

Энэ “Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулаад авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол гаргах шаардлагатай байгаа.

Тогтоолын төсөл Байнгын хорооноос бэлдсэн. Би та бүхэнд уншиж танилцуулъя. Тогтоолын төслөө өг дөө.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай”.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.2023 оны 5 сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын нэгт заасан хавсралтад дурдсан хугацаанд багтаан холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулах ажлыг зохион байгуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасугай.

3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, Төрийн ордны барилга, байгууламж, нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны танхим, өрөө тасалгааны зохион байгуулалттай холбогдох зураг төсөл, техник тоног төхөөрөмж, программ хангамжийн өөрчлөлт хийхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

4. Энэ тогтоолын 3-т заасан арга хэмжээний хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гаргах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

5. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар Өлзийсайханд энэ орчихсон юм уу. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

1. Улсын Их Хурлын Тамгын газрын бүтэц, орон тоо, цалингийн сан, үйл ажиллагааны төсвийн төслийг боловсруулж шийдвэрлүүлэх.

2. Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, эрх зүйн бусад актыг боловсронгуй болгох арга хэмжээ авч ажиллах.

6. Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

Нэгдүгээр хавсралтад нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт Их Хурлын сонгуулийн тухай хуулийг энэ 23 оны хаврын ээлжит чуулганаар, Улс төрийн намын тухай хуулийг 23 оны хаврын ээлжит чуулганаар, Төрийн ордны тухай хуульд орох өөрчлөлт нэмэлт, өөрчлөлтийг 23 оны намрын ээлжит чуулганаар, Монгол Улсын

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг 23 оны намрын ээлжит чуулганаар, Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 оны намрын ээлжит чуулганаар, Монгол Улсын Их Хурлын тухай болон түүнтэй холбогдох бусад хууль тогтоомжийг Их Хурлын 24 оны намрын ээлжит чуулганаар, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг Улсын Их Хурлын 24 оны хаврын ээлжит чуулганаар тус тус нийцүүлэх арга хэмжээгүүдийг авах.

Хоёрдугаар хавсралт дээр ажлын хэсгийг баталсан байгаа. Их Хурлын 24 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын үйл ажиллагааг эхлэхэд шаардагдах бэлтгэлийг хангах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Их Хурлын гишүүн, Их Хурлын дэд дарга Мөнхбаатар, гишүүдэд Их Хурлын гишүүн Н.Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Тэмүүлэн Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга, Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд, Амарбаясгалан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Өлзийсайхан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Алтангэрэл Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, Тамир Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга, Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Нарийн бичгийн даргаар Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Батбаатарыг гэсэн ийм 2 хавсралттай тогтоолын төсөл танилцуулж байна.

Саналтай гишүүд байна уу? Алга байна.

Санал хураах бил үү энийг чинь. Дуусчихлаа тогтоолын төсөл байсан юм. 1, 2, 3, 4, 5, 6 саналаа хураачих уу тогтоол дээрээ. 70. Сүхээ тогтоол дээр саналаа хураачихъя.

Саяын тогтоолын төсөлтэй холбоотой асуулт гарсангүй, санал

гараагүй. Одоо тогтоолын төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй, оруулж батлуулъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Пүүжээ гишүүн ээ дараарай. Сараа.

54.5 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолтой холбогдсон Байнгын хорооны санал, дүгнэлтийг Сарангэрэл гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа.

Оролцсон гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.

15.15 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР